



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1982 оны 5 дугаар  
сарын 6 ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар  
хот

АХУЙ-и-и 1982 оны 161 р

ХОТ, РАЙОНЫ ХАМТАРСАН ТУСЛАХ АЖ  
АХУЙ БАЙГУУЛАХ ТУХАЙ

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 6-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны туслах аж ахуйг Багануурын районд төвлөрүүлж, хот, районы гүйцэтгэх захиргааны хамтарсан аж ахуйг мах, сүү, ногооны чиглэлээр Багануурт байгуулсугай. ✓
2. Туслах аж ахуйн 1982 оны программыг 5,0 га-д төмө, хүнсний ногоо тариалах, саалийн чиглэлийн 40 үнээ, 5 мэгж, үржүүлэх ажлыг эрхлүүлэхээр баталсугай. ✓
3. Багануур дахь туслах аж ахуйд зориулан 50 үнээ тугал, 10 мэгж, 500 өндөглөгчийн дулаан байрууд, 0,03 га талбайтай шилэн цамхаг, шилэн дарлага, 60 тоннын багтаамжтай ногооны зорийн төсвийг орон нутгийн хямд төсөр материал ашиглан хийхээр бодож, 6-р сарын I-ний дотор хийж өгөхийг хотын Архитектур төлөвлөлтийн газар /н.Мадамбаа/-т, уг барилга байгууламжийг хот, районы хүчээр 1982 онд багтааж аж ахуйн аргаар барихыг хамтарсан аж ахуй зөвлөлд даалгасугай.
4. Туслах аж ахуйн үйлдвэрийг зохион байгуулах, цаашид өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллуулах асуудлыг Багануур районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Пүрэвдорж/-д даалгасугай.
5. Туслах аж ахуй байгуулах, барилга барихад шаардагдах хөрөнгийг хот, районы гүйцэтгэх захиргаанаас хуваарилан гаргах, ногоо тариалах, хураах, арчлах, хадлан төжээл бэлтгэх, малын хашаа, байр барих зэрэг цаг үеийн ажилд хот, районоос хүн хүч хуваарилан гаргаж байхыг зөвлөлд даалгасугай.
6. Туслах аж ахуйн 1982 оны орлого зарлагын төсөв, орон тоо, цалингийн фондыг I,2-р хавсралтаар баталсугай.
7. Туслах аж ахуйн 1982 оны зардлын дутуу 58,0 мянган төгрөг, трактор, хадлан, усалгааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, үр бордоо худалдан авахад шаардагдах хөрөнгийг хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяа төсөвт газруудын 1981 оны арвилан хэмнэлтийн фондоос гаргаж өгөхийг Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.



8. Ашиг шимийн үнээ, бух, гахай, шувуу, ажлын мал, худалдан авах, малын хашаа байр барилга барихад зориулж 1982 онд 200,0 мянган төгрөгийн зээл олгохыг хотын банк /н.Совд/-т даалгасугай.

9. 1982 онд Хүнсний захад барихаар төлөвлөгдсөн өрөмдмөл худгийг Багануурт шилжүүлэн 6-р сарын 1-ний дотор барьж өгөхийг хотын Усны аж ахуй удирдах газар /н.Адилбиш/-т даалгасугай.

10. Хүнсний ногоо, малын төжөөл тариалахад зориулж хөдөө аж ахуйн зарим машинаар хангах, өндөр ашиг шим бүхий бух 2-ыг олж нийлүүлэх арга хэмжээ авахыг Хөдөө аж ахуй удирдах газар /н.Батсүмбэр/-т Төлөвлөгөөний комисс Сумаахүү нарт даалгасугай.

11. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны хамтарсан аж ахуйг аж ахуйн тооцоон дээр ажиллуулах, 1982 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг энэ оны 2-р улиралд багтаан хийж батлуулах, харилцах данс нээж ажиллахыг Багануурын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Пүрэвдорж/-д, даалгасугай.

12. Туслах аж ахуйг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг хотын Хөдөө аж ахуй удирдах газар /н.Батсүмбэр/-т даалгасугай.

13. Багануурын туслах аж ахуйг түшиглүүлэн мөн районы 10 жилийн дунд сургуулийн хөдөлмөр зусланг 1982 оноос эхлэн байгуулж, зарлыг туслах аж ахуйгаас гаргахыг Ардын боловсролын кэлтэс /н.Батмагнай/, Багануурын районы гүйцэтгэх захиргаа /н.Пүрэвдорж/-д даалгасугай.

14. Туслах аж ахуйн зөвлөлийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХААУ газрын дарга Батсүмбэр /дарга нь/ гишүүдэд Цэдэв, Тогоо, Ойдовсамбуу, Гунгаажав, Пүрэвдорж, Эрдэмбат нарын бүрэлдүүнтэй байгуулсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БИЧҮЙН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ